

АРВАЙХЭЭР СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2022 ОНООС  
2023 ОН ДАМЖСАН, 2023 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ҮР ДҮНГИЙН ТУХАЙ ТӨСВИЙН ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 03 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 01

Арвайхээр  
сум

Арвайхээр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оноос 2023 он дамжсан, 2023 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүнд хяналтын сонсгол 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр 11 цаг 10 минутад “Арвайхээр хуралдааны танхим”-д эхлэв.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ц.Доньддорж төсвийн хяналтын сонсголыг нээж үг хэлэв. Сонсголд Засаг даргын Тамгын дарга С.Ганчимэг, Санхүүгийн албаны дарга Ж.Ганзориг, нятлан бодогч Н.Нацагням, Арвайхээр Тохижилт үйлчилгээ, Гэрэлтүүлэг нийтийн тээвэр ОНӨААТҮГ-ын дуудагдаж ирсэн албан тушаалтнууд оролцлоо.

Мөн тендер гүйцэтгэгч 6 байгууллага оролцохоос Анкер хаус ХХК, Хөгшин хайрхан шүтээн ХХК-ний төлөөлөл оролцож, Монголиан мистери ХХК, Ундарга байгууламж ХХК, Ховд сафари ХХК, Баялаг говь ХХК-аас төлөөлөл оролцсонгүй.

Төсвийн хяналтын сонсголд оролцогч 3 бүртгүүлснээс 2 нь оролцож, ажиглагч бүртгүүлээгүй, Хэвлэл, мэдээллийн байгууллагуудаас Соёмбо телевиз, Арвайхээр чөлөөт суваг телевиз оролцохоо мэдэгдсэн ч арга хэмжээ давхцсан, Хөндлөнгийн шинжээч Либарал Эмэгтэйчүүдийн Оюуны сан төрийн бус байгууллагын Өвөрхангай аймаг дахь салбарын зохицуулагч Ч.Ганцэцэг хүндэтгэх шалтгаантай тус тус оролцсонгүй.

#### ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Арвайхээр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оноос 2023 он дамжсан, 2023 оны төсвийн зарцуулалт гүйцэтгэлийн үр дүнгийн тухай

#### ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Арвайхээр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оноос 2023 он дамжсан, 2023 оны төсвийн зарцуулалт гүйцэтгэлийн үр дүнгийн тухай

#### СОНССОН нь:

**Ц.Доньддорж** (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга) Сайн байцаана уу? Нийтийн сонсголд хүрэлцэн ирсэн та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Арвайхээр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оноос 2023 он дамжсан болон 2023 оны төсвийн зарцуулалт гүйцэтгэлийн үр дүнд сонсгол зохион байгуулж байна.

Монгол Улсын хэмжээнд нийтийн сонсголыг 2015 оноос эхлэн зохион байгуулахаар хуульчилсан. Өнөөдрийн нийтийн сонсголыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Э.Түмэнжаргал даргална. Нийтийн сонсгол даргалагчийг Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 20/05 дугаар тогтоолоор баталсан. Сонсгол даргалагч Төлөөлөгч Э.Түмэнжаргалыг урьж байна. Амжилт хүсье.

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ удаагийн сонсголын сэдэв бол “Арвайхээр сумын Орон

нутгийн хөгжлийн сангийн 2022 оноос 2023 он дамжсан, 2023 оны төсвийн зарцуулалт гүйцэтгэлийн үр дүнгийн тухай” байгаа. Хяналтын сонсголд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Нийтийн сонсголын тухай хуулийн 9.3-д заасны дагуу холбогдох журмын дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас “Арвайхээр сумын 2023 оны төсөв батласан” тогтоолд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 2022 оноос 2023 он дамжсан, 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд төсвийн хяналтын сонсгол” зохион байгуулах хүсэлт гаргасан.

Сонсголд оролцож байгаа дуудагдаж ирсэн албан тушаалтнууд, тендер гүйцэтгэгчид, оролцогчдыг танилцуулав. (ирцийн бүртгэл хавсралтаар)

Нийтийн сонсгол зохион байгуулах хөтөлбөрийн дагуу дэгийг танилцуулья. (дэгийг танилцуулав) Сонсголд ажиглагчаар бүртгүүлсэн хүн байхгүй, ажиглагч нь сонсголын үед асуулт асуух, үг хэлэх эрхгүй оролцдог. Оролцогчоор оролцох 3 хүн бүртгүүлж 2 нь хүрэлцэн ирсэн, 1 оролцогч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оролцох боломжгүй болсон гэдгээ мэдэгдсэн. Оролцогч нь асуулт асууж, үг хэлэх эрхтэй оролцоно.

Одоо дуудагдаж ирсэн албан тушаалтнуудыг танилцуулья. Засаг даргын Тамгын газрын дарга, С.Ганчимэг, Ерөнхий нягтлан бодогч Ж.Ганзориг, Хотын Захирагчийн албаны Ерөнхий менежер Б.Гал-Эрдэнэ, Хотын Захирагчийн албаны Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Ц.Наранбадам, Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга Д.Сүх-Өлзий, Арвайхээр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын дарга Ц.Энхжаргал, Хөгшин хайрхан шүтээн ХХК-ны төлөөлөл, Анкер хаус ХХК-ны төлөөлөл оролцож байна. Засаг дарга Б.Ганбат, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын дарга Д.Мягмар, Монголиан мистери ХХК, Ундарга байгууламж ХХК, Ховд сафари ХХК, Баялаг говь ХХК-аас төлөөлөл ирээгүй байна.

За дэгийн дагуу Арвайхээр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оноос 2023 он дамжсан болон 2023 оны төсвийн зарцуулалт гүйцэтгэлийн үр дүнгийн тухай мэдээллийг сумын Засаг дарга Б.Ганбат танилцуулах байсан боловч албан ажилтай ирээгүй учир ХЗА-ны Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Ц.Наранбадам мэдээлэл хийнэ.

**Ц.Наранбадам** (Хотын Захирагчийн албаны Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн) За нийтийн сонсголд хүрэлцэн ирсэн та бүхний өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Арвайхээр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оноос 2023 он дамжсан болон 2023 оны төсвийн зарцуулалт гүйцэтгэлийн үр дүнгийн талаар танилцуулья. 2022 оноос 2023 он дамжсан 3 төсөл арга хэмжээ байгаа. Үүнд:

1.Рашаант 8, Зүлэгт 12 дугаар багийн хүүхдийн тоглоомын талбай төсөл, арга хэмжээ 100 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тендер гүйцэтгэгч нь Монголиан местери ХХК;

2.Эрчим хүчний уналттай газрын шугамын өргөтгөл төсөл, арга хэмжээ 79 сая төгрөгний төсөвт өртөгтэй, тендер гүйцэтгэгч Анкер хаус ХХК;

3.Нийтийн бие засах газар төсөл, арга хэмжээ 50 сая төгрөгний төсөвт өртөгтэй, тендер гүйцэтгэгч нь Ундарга байгууламж ХХК байна.

Та бүхэнд хийж гүйцэтгэсэн ажлыг зурагтай нь танилцуулья. (PPT танилцуулав, тэмдэглэлд хавсаргав) Нийт 11 төсөл арга хэмжээ хийхээр төлөвлөсөн. Үүнд:

1.Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажил төсөвт өртөг 114,800.0 мянган төгрөг, гэрээний дүн 109,909.9 мянган төгрөг, санхүүжилтийн дүн 109,909.9 мянган төгрөг, тендер гүйцэтгэгч Ховд сафара ХХК, гүйцэтгэл 100 хувь.

2.Хог ангилан ялгах, дарж булах ажлыг эрчимжүүлэх, хогийн савны тоог нэмэгдүүлэх ажил төсөвт өртөг 100,000.0 мянган төгрөг, гэрээний дүн 100,000.0 мянган төгрөг, санхүүжилтийн дүн 99,000.0 мянган төгрөг, тендер гүйцэтгэгч Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, гүйцэтгэл 100 хувь.

3.Нохой, муур устгалын ажлыг зохион байгуулах, нохойн арьс боловсруулах тоног төхөөрөмжтэй болох ажил төсөвт өртөг 50,000.0 мянган төгрөг, гэрээний дүн 50,000.0 мянган төгрөг, санхүүжилтийн дүн 49,500.0 мянган төгрөг, тендер гүйцэтгэгч Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, гүйцэтгэл 100 хувь.

4.Их-Уул, Ягаантолгой 6, Бурхи 9 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбайг биеийн тамирын зориулалтын тоног төхөөрөмжийн хамт байгуулах ажил төсөвт өртөг 100,000,0 мянган төгрөг, гэрээний дүн 93,980.0 мянган төгрөг, санхүүжилт 93,040.2 мянган төгрөг, тендер гүйцэтгэгч Хөгшин хайрхан шүтээн ХХК, гүйцэтгэл 100 хувь.

5.Гэр хороолол, нийтийн эзэмшлийн талбайн камерийн тоог нэмэгдүүлэх ажил төсөвт өртөг 100,000.0 мянган төгрөг, гэрээний дүн 98,964.7 мянган төгрөг, санхүүжилт 59,378.8 мянган төгрөг, тендер гүйцэтгэгч Прожект девелопмент тотал солюшн ХХК, Санхүүжилт 60 хувь, гүйцэтгэл 95 хувь.

6.Нийтийн тээврийн ашиглалтыг сайжруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөвт өртөг 70,000,000 мянган төгрөг, гэрээний дүн 70,000.0 мянган төгрөг, санхүүжилт 69,300,0 мянган төгрөг, тендер гүйцэтгэгч Арвайхээр нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ, гүйцэтгэл 100 хувь.

7.Гэр хорооллын ус түгээх байруудыг ухаалаг системд шилжүүлэх төсөвт өртөг 55.444.2 мянган төгрөг, гэрээний дүн 55,272.0 мянган төгрөг, санхүүжилт 54,720.0 мянган төгрөг, тендер гүйцэтгэгч Баялаг говь ХХК, гүйцэтгэл 100 хувь.

8.Малчдын гар дээрээс ил задгай худалдан борлуулж байгаа мах, сүү, сүүн бүтээгдэхүүнийг төвлөрсөн цэгээр худалдаалах нөхцөлийг бүрдүүлэх ажил төсөвт өртөг 18.000.0 мянган төгрөг, гэрээний дүн 17.400.0 мянган төгрөг, санхүүжилт 17,166.6, тендер гүйцэтгэгч Хөгшин хайрхан шүтээн ХХК, гүйцэтгэл 100 хувь

9.Гэр хорооллын хотгор гүдгэр тэгшлэх ажил төсөвт өртөг 55,157.4 мянган төгрөг, тендер 3 удаа зарласан оролцогч материал ирүүлээгүй.

10.Багуудын усан сангийн тоог нэмэгдүүлэх ажил төсөвт өртөг 25,000,0 мянган төгрөг, тендер 3 удаа зарласан оролцогч материал ирүүлээгүй.

11.Багуудын хүүхдийн тоглоомын талбайн засвар төсөвт өртөг 60,000,0 мянган төгрөг, тендэр 2 удаа зарласан оролцогч материал ирүүлээгүй байна.

Нийт дүн төсөвт өртөг 748,401.6 мянган төгрөг, гэрээний дүн 595,526.6 мянган төгрөг, санхүүжилт 552,015.5 мянган төгрөг байна. За анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) За ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний танилцуулга, мэдээлэл хийсэн Ц.Наранбадам мэргэжилтэнд баярлалаа. Дэгийн дагуу Төрийн аудитын дүгнэлтийг сумын Санхүүгийн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч Ж.Ганзориг танилцуулна.

**Ж.Ганзориг** (Сумын Санхүүгийн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч) Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Арвайхээр сумын 2023 оны ОНХС-ийн санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг танилцуулъя. Арвайхээр сум 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 16-ны өдрийн 12/03 дугаар тогтоолоор 18 төсөл арга хэмжээг 856 сая төгрөгөөр, мөн “Арвайхээр сумын 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах” сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 сарын 06-ны 16/03 дугаар тогтоолоор 3 төсөл арга хэмжээг 140.1 сая төгрөгөөр тус тус хэрэгжүүлэхээр баталсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж гүйцэтгэгчид шалгаруулсан. Нийт 16 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1 төсөл арга хэмжээ 60 хувийн гүйцэтгэлтэй, 4 төсөл арга хэмжээ дараа онд буюу 2024 онд хэрэгжүүлэхээр тус тус тооцож санхүүгийн тайланг нэгтгэсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 961,1 сая төгрөг төлөвлөсөнөөс гүйцэтгэл нь 747,7 сая төгрөгийн гүйцэтгэлтэйгээр, зөрүү 240 сая төгрөг буюу 70 хувийн гүйцэтгэлтэй байна. 2023 оны санхүүгийн тайланг аймгийн Төрийн аудитад нэгтгүүлэн зөрчилгүй дүгнэлт авсан байгаа. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа. (мэдээллийг тэмдэглэлд хавсаргав)

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) За аудитын дүгнэлт танилцуулсан Санхүүгийн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч Ж.Ганзоригт баярлалаа. Дараагийн асуудал “Арвайхээр сумын 2022, 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийн тухай” иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга, Ажлын албаны дарга Ц.Тунгалаг танилцуулна.

**Ц.Тунгалаг** (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга) За та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хяналтын сонсгол хийж байгаа энэ тохиолдолд тогтвортой амьжиргаа төсөл 10 жилийн хугацаанд хэрэгжээд 2023 оны 12 сараар эцэслээд дууссан байгаа. Төслийн зохицуулагч маань ажлаа өгсөн учраас Хурлын Ажлын албанаас үр дүнгийн танилцуулгыг хийж байна. Орон нутгийн хөгжлийн сан, Тогтвортой амьжиргаа төслийн гол зорилго нь хөдөө орон нутагт засаглалыг бэхжүүлж, иргэдийн оролцоотой тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Өөрөөр хэлбэл төр өөрөө хууль журмын хүрээнд олгогдсон эрхээ эдэлж олгогдсон үүрэг хариуцлагаа үр дүнтэйгээр эдлэх хэрэгтэй. Иргэд тэгш хүртээмжэй оролцож үр дүнг нь тэгш хүртээмжтэй эдлэх зорилготой хөтөлбөр байгаа. Үүнийг сайн засаглал гэдэг. Хөдөө орон нутагт байгаа засаглалыг хэрэгжүүлэх гол зорилго бол иргэдийн оролцоо байдаг. Мэдээлэлтэй иргэн оролцоотой байдаг, мэдээлэлгүй иргэн оролцоогүй байдаг.

Ингээд та бүхэнд 10 жилийн харьцуулсан үр дүн болон 2023 оны үр дүнг танилцуулъя. Шалгуур үзүүлэлтийг харъя. 6 бүлгээр дүгнэсэн байгаа. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээг эрэмбэлэхэд олон нийтийн оролцоог хангаж буй байдал;
2. Төсвийн төлөвлөлт, бэлтгэлийг хангаж буй байдал;
3. Төсвийн талаар олон нийтэд ил тод мэдээлж буй байдал;
4. Төсвийн гүйцэтгэл;
5. Төсвийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, хяналт үнэлгээ хийсэн байдал;
6. Орон нутгийн хөгжлийн сангаар бий болсон хөрөнгийн бүртгэл гэх зэрэг шалгуураар жил бүр хийгддэг, хүснэгтийн тайлбар хэсгийг та бүхэн уншсан байх. Хэн хэн (байгууллага, албан тушаалтан) хариуцаж хийх чиглэлүүдийг тусгасан байна.

Арвайхээр сумаас гадна Өвөрхангай аймгийн хэмжээнд 2016-2023 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж үнэлгээг бид эндээс харж байна. Тод цэнхэр өнгө нь аймгийн дундаж үнэлгээ, бүдэг цэнхэр нь улсын дундаж үнэлгээ байгаа юм. 2016 онд аймаг 36 хувьтай байсан бол улсад 32 хувьтай байсан байна. Харьцуулахад 2023 онд аймгийн дундаж 77 хувь улсын дундаж 71 хувьтай харагдаж 80 хувь бол хүрээгүй байна. Яагаад ийм үнэлгээтэй байна вэ гэдгийг слайднаас дэлгэрэхгүйгээр харж байна.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээг эрэмбэлэхэд олон нийтийн оролцоог хангаж буй байдал аймаг 96 хувь, сумдын дундаж 85 хувьтай;

2. Төсвийн төлөвлөлт, бэлтгэлийг хангаж буй байдал аймаг 92 хувь, сумдын дундаж 72 хувьтай;

3. Төсвийн талаар олон нийтэд ил тод мэдээлж буй байдал аймаг 64 хувь, сумдын дундаж 53 хувьтай;

4. Төсвийн гүйцэтгэл аймаг 53 хувь, сумдын дундаж 62 хувьтай;

5. Төсвийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, хяналт үнэлгээ хийсэн байдал аймаг 76 хувь, сумдын дундаж 67 хувьтай;

6. Орон нутгийн хөгжлийн сангаар бий болсон хөрөнгийн бүртгэл аймаг 78 хувь, сумдын дундаж 77 хувьтай байна. Энэ бол улсын хэмжээнд гаргасан үзүүлэлт.

2023 оны үнэлгээг сум тус бүрээр үзүүлсэн байна. Хамгийн эхэнд Арвайхээр сум харагдаж байна. Өнгө тус бүрээр 2016-2023 онууд ялгарч харагдаж байна. Хамгийн сайн гүйцэтгэлтэй жил бол улсад 1-т орж байсан үнэлгээ.

2023 оны жилийн гүйцэтгэл бүлэг тус бүрээр харагдаж байна. Сумын үнэлгээний дундаж 95 хувьтай байна. Бусад сумдыг эндээс харьцуулаад харж болно. 2023 оны үнэлгээгээр 2024 онд авах санхүүжилтийн хэмжээ мөн сум сумаараа харагдаж байна. Арвайхээр 1-т 235 оноо авахаас 223 оноо авсан 95 хувийн гүйцэтгэлтэй 655 692,92 мянган төгрөгийн 30 хувь буюу 196 707,88 мянган төгрөгийн урамшуулал авч байна. Манай сум нутаг дэвсгэрийн онцлогоороо арай илүү үр дүнтэй явж байгаа.

За одоо бүлгээ задлаад Арвайхээр сумын хэмжээнд 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн шинжилгээг дэлгэрэнгүй үзье.

### **Бүлэг 1: 2024 оны төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангасан байдал**

- Үзүүлэлт 1: Багийн Засаг дарга нар иргэдээс саналын хуудас, бүлгийн ярилцлага, болон цахим хэлбэрийн аль нэгээр санал авсан эсэх 100 хувийн үнэлгээтэй.

- Үзүүлэлт 2: Багийн Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар иргэдийн ирүүлсэн саналыг иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалтыг бэлтгэхдээ хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний холбогдох мэдээллийг бүрэн тусгасан эсэх 92 хувьтай. Үүн дээр нэмэлт тайлбар хэлэхэд Нэг баг иргэдийн Нийтийн Хурлын материалдаа он сарыг буруу бичсэнээс болоод оноо алдсан. Жижиг гэлтгүй алдааг засч залруулж ажиллах хэрэгтэй. Баримт бичгээ аль аль талдаа сайн нягтлаж авч байх хэрэгтэй.

- Үзүүлэлт 3: Багийн иргэдийн Нийтийн Хурал (ИНХ)-ыг 6 дугаар сард багтан хүчин төгөлдөр ирцтэйгээр зохион байгуулсан эсэх 100 хувьтай.

- Үзүүлэлт 4: Багийн Засаг дарга нар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний иргэдийн санал асуулгад үндэслэн эрэмбэлсэн эсэх 100 хувьтай.

- Үзүүлэлт 5: Багийн Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх танилцуулгыг бүрэн бэлтгэж албан бичгээр хүргүүлсэн эсэх 98 хувьтай буюу 1-р бүлгийн дундаж 98 хувь байна.

**Бүлэг 2. Төсвийн төлөвлөлт 2022 онд 2023 оны Орон нутгийн хөгжлийн санг төлөвлөсөн байдал**

-Үзүүлэлт 6: Сумын Засаг даргын дэргэдэх ажлын хэсгийг (шинээр) байгуулж, бүрэлдэхүүнд холбогдох мэргэжлийн хүмүүсийг оруулсан эсэх 100 хувь.

-Үзүүлэлт 7: Ажлын хэсэг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн саналыг боловсруулахдаа 1 ба түүнээс дээш удаа хуралдсан эсэх 100 хувь.

-Үзүүлэлт 8: Ажлын хэсэг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг эрэмбэлэхдээ журмын дагуу холбогдох үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн эсэх 100 хувь.

-Үзүүлэлт 9: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт аймаг/сумын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан эсэх 100 хувь.

-Үзүүлэлт 10: Ажлын хэсгээс эрэмбэлэн боловсруулсан жагсаалтад тухайн төсвийн жилд шинээр эхлүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнүүд багийн иргэдийн саналаар дэмжигдсэн эсэх 100 хувь.

-Үзүүлэлт 11: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан сумын төсвийг хуулийн хугацаанд буюу 12-р сарын 20-ны дотор хэлэлцэж баталсан эсэх 100 хувь.

-Үзүүлэлт 12: Сумын төсвийг хэлэлцэж баталсан, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ирц бүрдсэн байдал 81 хувь, энэ бол хуралдааны дундаж ирц 81 хувь байсан түүгээр шууд тавигдсан оноо байгаа.

-Үзүүлэлт 13: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр санал болгосон хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нэг бүрийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцсэн эсэх 92 хувь.

-Үзүүлэлт 14: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг зохих маягтын дагуу баталсан эсэх 100 хувь.

-Үзүүлэлт 15: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авалтын аргыг сумын Засаг даргын баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд зөв тусгасан эсэх 100 хувь буюу 2-р бүлгийн дундаж 96 хувьтай гэх мэтчилэн 6 бүлгийг 35 үзүүлэлтээр үнэлсэн.

2023 онд гүйцэтгэлд суурилсан урамшууллын дүн 196,707,880 мянган төгрөг байна. 2016-2023 оны нийт урамшуулал 653,580,329 мянган төгрөг байна. Үзүүлэлт 27-д Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон эсэх гэдэгт 90 оноо авсан. Үүнд анхаарах хэрэгтэй байгаа юм. Үзүүлэлт 21-т Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хориглосон хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ болон бусад зардалд зарцуулсан эсэх гэдгийг мөн анхаарах хэрэгтэй.

**Бүлэг-5. Хяналт, шинжилгээ ба үнэлгээ:** 2022-2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр, төсөл арга хэмжээнд хяналт, үнэлгээ хийсэн байдалд 4 үзүүлэлт 100 хувьтай үнэлэгдсэн нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн хяналтын чиг үүргээ хэрэгжүүлсэн байдал, эргээд Хуралдаа тайлагнаж мэдээллэсэн байдал юм. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хороодын ажилласан байдлыг ирцтэй нь тулгаж үзэж өгсөн үнэлгээ байгаа.

**Бүлэг-6 Хөрөнгийн удирдлага 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон биет хөрөнгийн өмчлөл, ашиглалт:** Үзүүлэлт-35 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон эд хөрөнгийг сумын өмчлөлд бүртгэсэн, холбогдох этгээдэд хариуцуулсан байдал гэдэг дээр дөнгөж 50 хувьтай явж байгаа. Иймд Засаг даргын Тамгын газар, Хотын Захирагчийн алба ажлаа сайн төлөвлөөд эргээд иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаа хэлэлцүүлж, шийдвэрээ гаргуулж явах нь зүйтэй юмаа. Орон нутгийн хөгжлийн сангийн оруулалтаар бий болсон нийтийн өмчид анхаарч энэ ажлаа эрчимжүүлж ажиллах шаардлагатай. Өөрөөр хэлбэл сумын удирдлага, албан хаагчдыг дургүйцүүлэн Хурлаас энэ асуудлыг хэлэлцэх гээд Хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулаад, хурлын бэлтгэл ханга хэмээн шахаж шаарддагын учир энэ юм. Арвайхээр сумын урамшуулал бол жил бүр өссөн үзүүлэлттэй явж байна.

Цаашид анхаарах ажлууд:

-Төсөв батлахад иргэний төлөөллийг оролцуулах ажил бол манай сумын хувьд сайн хэрэгждэг уламжлал болсон ажил байгаа.

-Иргэдээс санал аваагүй төсөл арга хэмжээг батлахгүй байх - энэ асуудлыг манайх байнга анхаарах хэрэгтэй.

-Он дамжсан төсөл арга хэмжээг ИТХ-ын тэмдэглэлд тусган тогтоолын хавсралтын шилжих хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулах.

-Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээ нэг бүрээр хэлэлцүүлэх тэмдэглэлд тусгах.

-2024 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээг удирдлага мэдээллийн систем дээр хийх тул системд оруулах мэдээллийг цаг тухай бүрт нь үнэн зөв оруулах.

-2023 оны төсөл арга хэмжээ 1 бүрийг хүлээж авсан акт, тайлан, хөрөнгийг орон нутгийн болон төрийн өмчид бүртгэсэн, холбогдох этгээдэд хариуцуулсан байдалд анхаарах.

-Хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тайлан системд оруулах зэрэгт онцгой анхаарах хэрэгтэй байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээд, гүйцэтгэх засаглал хуулиар хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж харилцан алдаагаа засаад явах хэрэгтэй гэж хэлэх байна.

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) Ц.Тунгалаг даргад баярлалаа. Хөндлөнгийн үнэлгээг дэлгэрэнгүй танилцууллаа. Энэ үнэлгээ Либерал эмэгтэйчүүдийн оюуний сангийн Өвөрхангай салбарын зохицуулагч Ч.Ганцэцэг танилцуулах байсан боловч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ирж амжаагүй. За одоо асуулт хариултдаа орно оо. Асуулт асуух оролцогч гараа өргөнө үү. За оролцогч Д.Буянтогтох.

**Д.Буянтогтох** (1-р багийн оролцогч) За та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн сонсголд оролцох ёстой тендер гүйцэтгэгч нар нь ирээгүй юм байна гэж бодож байна. Тендер зарлахаар өдөр шөнөгүй гүйж байгаад тендер авчихдаг.

Сонсгол хийгээд асуудлаа хэлэлцье гэхээр ингээд алга болчихдог. Хурлын ажлын албанаас бүгдэд нь албан мэдэгдэл хүргэж мэдэгдэл өгсөн байх. Худалдан авах ажиллагаар холбогдож ажлаа гүйцэтгүүлсэн Засаг даргын Тамгын газар ч бүрэн оролцох тал дээр анхаарах хэрэгтэй. Хоёрхон тендер гүйцэтгэгч ирсэн байна. Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын даргаас асуух асуулт байна. Нохойны арьс элдэж боловсруулах тоног төхөөрөмж авсан түүнийгээ 100 хувь ашиглаж байна уу? Мэдэгдэх юм алга. Дараа нь тэр Хөгшин хайрхан шүтээн ХХК гэж ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани вэ? гэдгийг тодруулъя.

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) Дуудагдаж ирсэн албан тушаалтан Д.Сүх-Өлзий дарга эхний асуултад хариулъя.

**Д.Сүх-Өлзий** (Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга) Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нэхий элдэх, нохойны арьс элддэг тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж авсан одоогоор бол ажиллаагүй байгаа яагаад гэхээр улирлын чанартай өвөл элдэж болдоггүй болохоор болохгүй байна хавар дулаараад ирэхээр ажил жигдрээд явна.

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) Дараагийн дуудагдаж ирсэн албан тушаалтан Хөгшин хайрхан шүтээн ХХК-ны төлөөлөл асуултад хариулаарай.

**Д.Мөнхбаяр** (Хөгшин хайрхан шүтээн ХХК-ны төлөөлөл) Энэ компани нь болохоор хүнсний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани байгаа. Худалдааны талаар л үйл ажиллагаа явуулж байна даа. 3 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа 6-р багийн тоглоомын талбай, малчдын гар дээрээс ил задгай худалдан борлуулж байгаа мах, сүү, сүүн бүтээгдэхүүнийг төвлөрсөн цэгээр худалдаалах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шовгорыг нийлүүлсэн.

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) Өөр асуулттай оролцогч байна уу? За 12-р багийн иргэн Д.Баасансүрэн.

**Д.Баасансүрэн** (12-р багийн оролцогч) За сайн байцгаана уу? Би 12-р багаас оролцож байгаа Баасансүрэн гэж хүн байна аа. Манай багт тоглоомын талбай баригдсан. Тоглоомын талбайг хүлээж авах ажилд иргэний Хяналтын зөвлөлийн гишүүн гэдгээрээ би оролцож байсан. Тэгэхэд дутуу ажлууд их, тэгээд үүрэг даалгавар өгч байсан. Түүнээс хойш би тэр ажилд оролцож чадаагүй тэр өгсөн үүрэг даалгавар яасан бол гэж асуумаар байна. Одоо жишээ нь хүүхдийн гулгуурын шатны зай хол, явган хүний зам, усан ориглуур, гэрэлтүүлэг хийгээгүй гэх мэт ажлууд дутуу байсан. Мөн нийтийн тээвэртэй холбоотой бас нэг асуулт тодруулга байна нийтийн тээвэр зах дээр маш удаан зогсдог 20-30 минут орчим. Энэ хүлээлгийг арай наашлуулж, богино хугацаанд түргэн шуурхай явуулах талаас нь арга хэмжээ авч болдоггүй юм уу?.

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) Д.Баасансүрэн оролцогчийн асуултад хэн хариулах уу? Загаг даргын Тамгын газрын дарга С.Ганчимэг, Хотын Захирагчийн албаны ерөнхий менежер Б.Гал-Эрдэнэ хэн нь хариулах уу? Дараа нь Х.Энхжаргал дарга хариулаарай.

**С.Ганчимэг** (Засаг даргын Тамгын газрын дарга) Өдрийн амгаланг айлтгая. За анх 8,12-р багийн тоглоомын талбайг хүлээж авах ажил 2023 оны 07 дугаар сарын 23-нд ажилласан. Тэр үед Д.Баасансүрэн гуайтай бид хамт явсан. Тэгээд үүрэг даалгавар өгөөд ажлын гишүүдийн саналаар 2023 оны 07 сарын 25-наас 08 сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэх үүрэг өгсөн. 08 сарын 02-нд



хүлээж авсан. Үүнд: Сагсны тайлбайн хашлага бэхэлгээ хийх, явган хүний замыг хаалга хүртэл гүйцээх, сүүдрэвч ширээний тавцан солих, гулсуурын шатыг бариултай болгох, гадна хайсыг будах, мод тарих ажлуудыг хийлгэж хүлээж авсан. 08 сарын 03-нд хийсэн ажлын тайлангаа ирүүлсэн. Мөн усан ориглуурын дотор талд пилта наах ажил үлдсэн байсан тэгээд 10 сарын 25-нд дахиж комисс ажиллаад хүлээж авсан.

**Х.Энхжаргал** (Арвайхээр гэрэлтүүлэг, нийтийн тээвэр ОНӨААТҮГ-ын дарга) Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Арвайхээрийн нийтийн тээвэр ерөнхийдөө 4 чиглэлд явдаг байсан одоо 2 чиглэлд 4 автобус 2, 2-оороо явж байна. Иргэдээс ирсэн гомдол хүсэлтийн дагуу ар араас нь явуулах байдлаар ажиллаж байна. 1 автобус зах дээрээс хөдлөөд 1, 9, 12, 2, 7-р багаар тойроод ирэхэд бүтэн тойрч байгаа гэсэн үг. Ингэхээр 30-35 минут явж байгаа дараагийн автобус нь 20 минутын зайтай хөдөлдөг. 1-2 хүнтэй байсан ч 30 минутаас хэтрэхгүй хүлээгээд явдаг. Манайх 1 хүнтэй 1 тойроход 8 литр бензин зарцуулдаг, 5 хүнтэй явбал энэ асуудал бас арай өөр. Автобусны кондукторууд орлогоороо цалинждаг ер нь хэцүү. Автобусны цагийн хувьд тэгж л явахаас өөр арга байхгүй.

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) С.Ганчимэг дарга хариулт өглөө, энэ тендерийг гүйцэтгэсэн Монголиан мистери ХХК-аас төлөөлөл ирээгүй байна. Байгаа бол уг нь мэдээлэл өгөх шаардлагатай. Нилээд чанаргүй ажлууд хийгдсэн байсан, хэд хэдэн ажлын хэсэг ажилласан. 9-р сард Төлөөлөгчдийн ажлын хэсэг ажилласан. Шаардлага хангахгүй хэцүү(хямдхан, эдэлгээ даахгүй чанар муутай) л материалаар хийсэн ажлууд харагдсан. Тэгээд үүрэг чиглэл Засаг даргын Тамгын газарт өгсөн, Засаг даргын Тамгын газраас ажлын хэсэг ажилласан гэж ойлгож байгаа. Энэ компаниуд авсан ажлаа чанартай гүйцэтгэчихвэл зүгээр байгаа юм. Тэгэхгүй эргэж уулзахгүй юм шиг чанаргүй ажил хийж байгаа ХХК-ууд олон байгаа. Санхүүжилт дутуу бол түүн дээр нь тэр засах ажлуудыг нь хийлгэ. Нийтийн сонсгол гэдэг бол иргэдээс саналаа аваад жил бүр хийсэн ажлууд дээрээ зохион байгуулж санал солилцдог.

**Д.Баасансүрэн** (12-р багийн оролцогч) Камержуулалтын ажил юу болж байна. Манай 12-р багийн хэсгийн ахлагчид хөброндоо ярьцгаасан. Өөрсдөө мөнгөө цуглуулаад гудамжиндаа тавьж үзье гэж.

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) Энэ асуултад Хотын Захирагчийн албаны ерөнхий менежер Б.Гал-Эрдэнэ хариулна уу.

**Б.Гал-Эрдэнэ** (Хотын Захирагчийн албаны Ерөнхий менежер) Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Арвайхээр хотын гэр хорооллын камерын ажил хийгдэж байгаа. РТЗ 4 камерын байршуулах цэгийг түрүүн хэлсэн Өлзийт хайрхан, Ягаан толгой, 12-р багийн баруун дэнжид хуучин камерын үзүүлэлтээс илүү хүчин чадалтай камер тавина. Гэр хороололд чиглэлийн 12 камер байгаа үүнийг багийн Засаг дарга нартай ярилцаж байршлыг тогтсон. Цамхагт гэрлийн шон дээр суурьлуулсан камер ажиллаж байгаа. Хятадын цагаан сартай холбоотой бараагаа нийлүүлээгүй байна.

**Д.Буянтогтох** (1-р багийн оролцогч) Надад дахиад нэг асуулт байна. Хөдөө аж ахуйгаас хэн байх вэ. Малын хөлийн татвараар ямар ажил хийсэн бэ? мэдээлэл авмаар байна. Малчиддаа хэрэгтэй ямар ажил хийв. 1-р багт дарга нар явдаггүй болоод тэгдэг юм уу та нар очоод хараарай. Аюулгүйн тойргоос 1, 9, 12-р багийн төв хүртэл ямар ч гэрэл байхгүй, хогийг нь цэвэрлэхгүй, төвөө л цэвэрлэдэг. Гэрлээ хэмнэдэг юмуу нохой ихтэй, дэлгүүр олонтой, хүүхдүүд их зам

хөндлөн гарч гүйдэг. Автобус байна 2, 7-р багаар тойрдогч юм уу, үгүй юу? Автобус нь бүтэхгүй болохоор ахмадууд нь гараад мотоцикл такси унаж бэртчих гээд явдаг. Энэ тулгамдсан асуудлуудаа сайн ярилцаж шийдвэрлэх хэрэгтэй. Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг болон Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2 дарга сууж байна эдгээр асуудлыг анхааралдаа аваарай. Хариуцсан ажилдаа хариуцлагатай хандаж баймаар байна.

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) Д.Буянтогтох оролцогчийн эхний асуултад хариулаарай. 2 дахь нь санал гэж ойлголоо. Та бүхэн бичиж тэмдэглэж аваад ажлаа сайжруулаарай. Нэг дэх асуултад Нягтлан бодогч Н.Нацагням хариулна.

**Н.Нацагням** (Нягтлан бодогч) Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Та бүхэнд малын хөлийн татвараар хийж гүйцэтгэсэн төсөл арга хэмжээг танилцуулъя.

1.Малын хөлийн тоо толгойн татвараар хийгдсэн төсөл арга хэмжээний мэдээлэл								
№	Төсөл арга хэмжээний нэр	Батлагдсан төсөвт өртөг	Малын хөлийн татварын орлого төвлөрсөн	Гэрээний дүн	Өгсөн санхүүжилт	Малын хөлийн татвараас санхүүжсэн	Төсөл арга хэмжээ гүйцэтгэгч	Тайлбар
1	Бэлчээрийн менежментийг сайжруулах	20,000,000		10,624,100	10,130,100	10,130,100	Хөдөө аж ахуй тасаг	Малчидын бүсийн зөвлөгөөнд 3,268,000, бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх /бактрижуулсан будаа/ 4,374,600, малын ялган тэмдэглэж бүргэлжүүлэх, ээмэгжүүлэхэд нийт 2,981,500 тус тус зарцуулсан.
2	Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх (хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхний хэсгийг хамгаалах)	20,000,000		18,000,000	18,000,000	18,000,000	Хөдөө аж ахуй тасаг	Арвайхээр сумын Дайргын голын тариалангийн талбайн толгойн боолт, усалгааны шуудууны ажлын зураг төсөв боловсруулахад 18 сая төгрөг
3	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	15,000,000		7,788,500	7,788,500	7,788,500	Мал эмнэлэг үйлчилгээний нэгж	Мал гоц халдварт өвчнийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2 удаа зохион байгуулахад 7,788,500 төгрөг.
4	Малын чанарыг сайжруулах	19,000,000						
5	Тэжээлийн нөөц бүрдүүлэх	70,000,000		58,784,000	58,784,000	58,784,000	Хөдөө аж ахуй тасаг	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд нарийн ногоон өвс, хивэг, ногоон тэжээлд нийт 58,784,000 төгрөг
	Дүн	144,000,000	94,836,450	95,196,600	94,702,600	94,702,600	133,850	

**Э.Түмэнжаргал** (Сонсгол даргалагч) Нягтлан бодогч Н.Нацагнямд баярлалаа. За ингээд өнөөдрийн сонсголын асуулт хариултыг үүгээр тасалъя. 2023 онд Орон нутгийн хөгжлийн санд хийгдсэн нийтийн сонсголыг зохион байгууллаа. Төлөвлөлтийг бол 90-ээс дээш хувь төлөвлөж чадаж байна. Иргэдээс санал авч эрэмбэлэхдээ бас учир дутагдалтай байна. Тийм учраас энэ бүхэн дээрээ анхаарч ажиллах. Төлөвлөлт 90-ээс дээш хувьтай байхад гүйцэтгэл нь 70 хувьтай байна гэдэг нь он дамжсан ажлууд хийгдэхгүй байгаатай холбоотой байх.

Төсөл, арга хэмжээнүүд зураг төсөвгүй ажлыг гүйцэтгэх засаглалаас хүчээр батлуулж, тендер гүйцэтгэгч шалгаруулалтад оролцохгүйгээс он дамжих, чанаргүй хийх шалтгаан бас болж байгаа. Өнөөдрийн сонсголд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Дараа дараагийн сонсголд захиалагч талаас тендер гүйцэтгэгчдийг бүрэн оролцуулах тал дээр Засаг даргын Тамгын газар анхаарч ажиллаарай. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1.Хууль тогтоомжийн хүрээнд иргэдийн Нийтийн Хуралдааны нэгтгэл эрэмбэд ороогүй, зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээ хэлэлцэхгүй, батлахгүйг анхаарах;

Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт:

1.Төсөл, арга хэмжээг хууль тогтоомж зөрчин батлуулснаар зураг төсөвгүй, тендер гүйцэтгэгч шалгаруулалтад оролцохгүйгээс он дамжих шалтгаан болсонд анхаарах;

2.Дараагийн сонголд захиалагч талаас тендер гүйцэтгэгчдийг бүрэн оролцуулах;

3.Иргэдийн саналаар эрэмблэгдсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг саналуудыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, 2025 оны төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд тусган, алдааг засаж, ажлаа сайжруулан хууль тогтоомжийн дагуу ажиллах чиглэл өгөв.

Сонгогч 12 цаг 34 минутад дуусав.

ТАНИЛЦСАН:

СОНСГОЛ ДАРГАЛАГЧ

Э.ТҮМЭНЖАРГАЛ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ИТХ-ЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ОЮОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ  
МЭРГЭЖИЛТЭН

М.ДЭЖИДМАА